Golomt Capital®

# Хөрөнгийн зах зээлийн тойм

Голомт Капитал ҮЦК ХХК-д бэлтгэв 2024.03.11

## Олон улсын хөрөнгийн зах зээл

# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

2024 он 03 сарын 11

## ТОВЧ

- АНУ-ын Хувийн хэрэглээний индекс /PCE/ 2.8 хувь буюу хүлээлтийн дагуу гарлаа
- БНХАУ-ын зах зээлийн тоон үзүүлэлтүүд Цагаан сарын амралтын өдрүүдтэй холбогдуулан суларсан байна
- АНУ зах зээлд NVIDIA компанийн хувьцаа зохиогчийн эрхийн зөрчилтэй холбоотойгоор 5.55 хувиар уналаа.
- АНУ-ын хагас дамжуулагчийн хориг арга хэмжээнүүд өсөж байгаатай холбоотойгоор БНХАУ улс 27 тэрбум ам.доллароор Чип Фанд байгуулна.
- АНУ-д 2-р сард шинэ ажлын байрны тоо 255 мянгаар өссөн ч ажилгүйдлийн түвшин 3.7-3.9%-д хүрч өслөө.

| Индекс | Утга |
|---|---|
| Dow Jones | 38,722.69 |
| S&P 500 | 5,123.69 |
| Nasdaq | 16,085.11 |
| DAX | 17,810.75 |
| FTSE 100 | 7,659.74 |
| S&P/ASX 200 | 7,847.00 |
| HANG SENG | 16,353.39 |

### АНУ-ын индексийн өгөөж

| Индекс | Өдрийн | Долоо хоног | Сар | Жилийн эхнээс | Жил | 3 жил |
|---|---|---|---|---|---|---|
| Dow Jones | -0.18% | -0.69% | -0.19% | 2.74% | 21.35% | 18.13% |
| S&P 500 | -0.65% | -0.14% | 2.03% | 7.42% | 32.68% | 29.93% |
| Nasdaq | -1.16% | -0.76% | 0.89% | 7.15% | 44.40% | 20.76% |

2024 оны 03 сарын 11-ны 10:00



### Европын индексийн өгөөж

| Индекс | Өдрийн | Долоо хоног | Сар | Жилийн эхнээс | Жил | 3 жил |
|---|---|---|---|---|---|---|
| DAX | -0.02% | 0.53% | 4.54% | 6.32% | 15.44% | 22.81% |
| FTSE 100 | -0.43% | 0.25% | 1.14% | -0.95% | -1.14% | 13.29% |

2024 оны 03 сарын 11-ны 10:00



### Ази Номхон далайн индексийн өгөөж

| Индекс | Өдрийн | Долоо хоног | Сар | Жилийн эхнээс | Жил | 3 жил |
|---|---|---|---|---|---|---|
| S&P/ASX 200 | -1.66% | -0.26% | 1.33% | 1.65% | 7.99% | 14.02% |
| Hang Seng | 1.06% | -0.55% | 4.81% | -3.19% | -14.58% | -42.57% |

2024 оны 03 сарын 11-ны 10:00



**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

## АНУ-ЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

**Эдийн засагт ажиллах хүчний тоо нэмэгдсэн ч ажилгүйдлийн түвшин өсөв:** 2-р сард АНУ-д нийт 275,000 ажлын байр шинээр нэмэгджээ. Харин 2-р сарын ажилгүйдлийн түвшин 3.7%-3.9%-д хүрч өслөө. АНУ-д цалингийн хэмжээ 2-р сард 0.1%-иар өссөн нь хүлээлт болох 0.5%-иас бага үзүүлэлт байна. Илүү олон иргэд ажил идэвхтэй хайж байгаа нь ажиллах хүчнийг өсгөж, энэ нь цаашлаад ажилгүйдлийн түвшин өсөхөд нөлөөлж байгаагаас гадна ажлын байрны эрэлт их буй нь цалингийн өсөлт доогуур байх үндсэн шалтгаан болсон гэж харж байна. Нөгөө талд компаниуд зардлаа танаж буй тул шинээр зарлагдах ажлын байрны тоо бага байна.

**Жижгүүд өсөж, томчууд уналттай байлаа:** S&P400 Midcap индекс 5-дахь өдөр бүх цаг үеийн дээд түвшнээ шинэчлэн тогтоосон бол Apple компанийн Хятад дахь борлуулалт буурсантай холбоотой хувьцааных нь ханш унасан бол Novo Nordisk компани Теслаг ардаа орхиж зах зээлийн үнэлгээгээр 12-т орлоо.

**ХНС бодлогын хүүгээ бууруулах хугацааг хойшлуулахгүй гэдэгт итгэлтэй байна:** ХНС-ийн тэргүүн Жером Пауэлл өмнөх олоо хоногийн дундуур Конгресст мэдүүлэг өглөө. Тус мэдүүлгийн үеэр инфляц тогтвортой байхыг дурдан, бодлогын хүү бууруулах шийдвэр холгүй байгааг мэдэгдлээ. Тус мэдэгдлийн дараа АНУ-ын 10 жилийн хугацаат бондын өгөөж 4.03%-д хүрлээ.

### График 1: NVIDIA Corporation компанийн хувьцааны ханш




NVIDIA компани 5.55 хувиар уналаа. Баасан гарагт Сан Францискогийн холбооны шүүхэд зохиогч Брайан Кин, Абди Наземиан, Стюарт О'Нан нар нэхэмжлэл гаргасан гэж Ройтерс агентлаг мэдээллээ. Тэдний бүтээлийг Nvidia-ийн өөрийн NeMo хиймэл оюун ухааны платформдоо зохиогчийн эрхгүй ашигласан гэж мэдэгджээ.

**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

# Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

## БНХАУ-ЫН ЗАХ ЗЭЭЛ

Өнгөрсөн долоо хоногт Бүх Ардын Төлөөлөгчдийн хурлын үеэр БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 5 гаруй хувь байх зорилт тавигдсанаар өнгөрсөн жилийн target үзүүлэлтэд төдийлөн өөрчлөлтөд ороогүй байна. Гэсэн хэдий ч шинжээчдийн үзэж буйгаар өнгөрсөн оны 5.2 хувийн өсөлтийг давахад 2024 онд тийм ч амар байхгүйг тэмдэглэж байна. Энэ нь өнгөрсөн онд цар тахлын хориг арга хэмжээ суларч эдийн засаг сэргэж эхэлсэнтэй ихээр холбоотой.

Түүнчлэн, тус хурлын үеэр Ерөнхий сайд Ли Чянг үл хөдлөхийн салбарын сэргэлтэд анхаарлаа хандуулж төрийн дэмжлэгтэйгээр орон сууцны асуудлыг шийдэх талаар ярьсан байна. Үл хөдлөх салбараас гадна Ерөнхий сайд технологийн салбар буюу тэр дундаа big data болон квантын тооцооллын хөгжлийг урагшлуулах тал дээр засгийн газар түлхэц үзүүлэхийг мэдэгджээ.

Үл хөдлөхийн салбар дахь уналт China Vanke үл хөдлөх хөгжүүлэгчийн санхүүгийн тогтворгүй байдлыг дагуулан үргэлжилсээр байна. Үүнтэй холбогдуулан зохицуулагч байгууллагууд банк санхүүгийн байгууллагуудтай хэлэлцэл өрнүүлж тус компанид санхүүгийн дэмжлэг үзүүлж өрийн төлбөрийн хугацааг уртасгах арга хэмжээ авах талаар ярилцсан байна. Мөн China Vanke-ийн зүгээс даатгалын компаниуд болох Taikang Insurance, PICC Property, Casualty болон New China Life Insurance нар өрийн төлбөрийн хугацааг сунгахыг хүлээн аваад байна.

**График 2: China Vanke компанийн хувьцааны ханш**




China Vanke Co LTD (HKEX:2202) хувьцааны ханш оройн цэг болох 42.85 HKD-ээс 87%-иар унаж 5.69 HKD-д ирээд байна. Цаашид хувьцааны ханш унах боломжтой бөгөөд унах боломжит ханш 3.72 HKD, доод боломжит ханш 1.98 HKD-д тус тус байна.

**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

# ТАЙЛАНГИЙН ХУАНЛИ

## Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд




## Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд




**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.